



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 9.11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 9.11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын захирлыг томилох эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шаардлага хангаагүй албан тушаалтныг томилсон бол тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР